



Өмнөговь аймаг дахь Төрийн Аудитын
газар

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор
Н.Отгонбаяр
Утас: 70533539
Цахим хаяг:
Azaa_otgoo@yahoo.com

Аудитын менежер:
Д.Алдармөнх
Утас: 70533552
Цахим хаяг:
Aldarmunkh_court@yahoo.com

Ахлах аудитор:
Ш.Наран
Утас: 70533552
Цахим хаяг:
Sh_naran@yahoo.com

ТАБ-ын хаяг: Өмнөговь аймаг
дахь Төрийн Аудитын газар
Байршил: Нутгийн удирдлагын
ордон 3 давхар 305 тоот
Цахим хуудас:
www.umnugovi.audit.gov.mn

2017 оны 4 дугаар сар

Аудитын код: ӨМА-2017/1/СТА-ТЕЗ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	17
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал..	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	19
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	19
2.12	Шилэн дансны мэдээлэл	20
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	21
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	21
3	Менежментийн захидал.....	22
3.1	<u>«management_zurchil1»</u>	
3.2	<u>«management_zurchil2»</u>	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	26
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	26
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	28
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	36

1 Аудитын гэрчилгээ



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.НАРАНБААТАР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

213014 Өмнөговь аймаг, Даланзадгал сум
3-р баг Нутгийн удирдлагын ордон
Утас: 7053-3539 E-mail: umnugovi@audit.gov.mn

2017.04.14 № 1/146 ОМА-2017/01/СТА-ТЭЗ
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Өмнөговь аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.ОТГОНБАЯР

D:Bichig hereg/Auditiin Gerchilgee-A4

71 233

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг дарга Н.Наранбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.4 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд төсөл, хөтөлбөр боловсруулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Өмнөговь аймгийн засаг даргын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Өмнөговь аймаг дах Төрийн аудитын газрын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 01- нээс 2017 оны 04 дүгээр сарын 20– ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, аймгийн Засаг дарга Н.Наранбаатарт хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Ш.Наран, аудитор Г.Цэрэнлхам, шинжээч С.Одончимэг, Г.Шижирболд нар аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитын төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тушаал
- Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 03 дугаар сарын 30 –ны өдрийн 1-515 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна.
Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан 15
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Төсөвт байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлан
- Төрийн сангийн 2016 оны санхүүгийн тайлан
- ОН-ийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2016 оны санхүүгийн тайлан
- Төсөл, сангуудын 2016 оны санхүүгийн тайлан

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал”-ын дагуу “Э –тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

ОН-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ын санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
ТЕЗ-ын санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
ТЕЗ-ын мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ТЕЗ-ын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Төсвийн ерөнхийлөн захирагийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 6 буюу бага байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих аудитын

горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.6 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлж ТАБ-СТА-В-6 маягтийг хэрэгжүүлэн ажиллаа.

Тоон ба чанарын шинжтэй асуудлаас гадна аливаа зүйлийн онцлог шинж чанар ач холбогдолоор үнэлэж орлого бүрдүүлдэг байгууллага тул төсвийн орлогын дүнгийн 0,6 хувь буюу 1,367.1 сая төгрөгөөр тооцох нь үнэ цэний хувьд боломжтой гэж үзэв.

Төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

2.7 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав.

Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ОН-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨААТҮГ-ууд, төсөл сангийн харилцахын үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө.

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,136.6 сая төгрөг байсан бол тайлант онд 63,2 хувиар өсч 19,207.8 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд үүний 9,0 хувь буюу 1,729.8 сая төгрөг нь арилжааны банкны үлдэгдэл байна.

ТЕЗ-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

					(сая төгрөгөөр)	
					Банкинд байгаа мөнгө	Төрийн сангийн нэгдсэн данс
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
Кассад байгаа бэлэн мөнгө	6.0	2.0	2.0			
Төгрөг/ЖМС	6.0	2.0	2.0			

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Банкинд байгаа бэлэн мөнгө	12130.6	19205.8		1729.8	17476.0
Төгрөг	12130.6	19205.8		1729.8	17476.0
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	12136.6	19207.8	2.0	1729.8	17476.0

Авлагын бүртгэл, тайлагналын талаар:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын эхний үлдэгдэл 16,697.5 сая төгрөг байсан бол тайлант онд 1,207.7 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцсийн үлдэгдэл 15,489.8 сая төгрөг болж тайлагнагдсан байна.

Авлагыг бүтэц, төрлөөр нь харуулбал:

				/сая төгрөгөөр/	
№	Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/ Бууралт -/-	
1	Ажиллагчидтай холбогдсон авлага	27.9	27.1	-0.8	
2	Төлбөртэй үйлчилгээний авлага	77.2	53.1	-24.1	
3	Татаас, санхүүжилтийн авлага	20.2	62.6	42.4	
4	Зээлийн хүүгийн авлага	37.7	29.8	-7.9	
5	Дансны авлага	55.3	53.2	-2.1	
6	Татвар НДШ-ын авлага	4.1	14.1	10	
7	Байгууллагаас авах авлага	13258.6	11276	-1982.6	
8	Хувь хүмүүсээс авах авлага	3216.5	3822.3	605.8	
9	Зээлийн авлага	0	151.6	151.6	
	Нийт	16697.5	15489.8	-1207.7	

Нийт авлагын 70,7 хувь буюу 10,958.9 сая төгрөгийг “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд аж ахуй нэгж байгууллага, иргэнд олгосон зээлийн авлага эзэлж байна.

Авлага өмнөх оноос 1,207.7 сая төгрөгөөр буурсан ч зарим нэр төрлийн авлага өссөн харагдаж байна. Үүнд: татаас санхүүжилтийн авлага 42.4 сая төгрөг, Татвар НДШ-ын авлага 10.0 сая төгрөг, Хувь хүмүүсээс авах авлага 605.8 сая төгрөг, зээлийн авлага 151.6 сая төгрөгөөр тус тус өссөн харагдаж байна. Бусад авлагууд 0.8 аас 1,982.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны авлагатай харьцуулбал:

/сая төгрөгөөр/



Бараа материалын бүртгэл тайлагналын талаар:

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 4,406.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 24,644.4 сая төгрөгөөр тайлагнаж, тайлант онд 20,237.8 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалыг нэр төрлөөр нь харуулбал:

/Сая төгрөгөөр/

№	Бараа материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт Бууралт	/+/-/ Хувь
1	Тусгай зориулалтын материал	201.7	329.4	127.7	1.3
2	Эм боох материал	135.1	155.3	20.2	0.6
3	Дуусаагүй үйлдвэрлэл	9.6	3.8	-5.8	0.02
4	Бэлэн бүтээгдэхүүн	115.9	154.1	38.2	0.6
5	Бичиг хэргийн материал	124.9	116.4	-8.5	0.5
6	Аж ахуйн материал	1616.8	1949.8	333	7.9
7	Сэлбэг хэрэгсэл	159.5	152.3	-7.2	0.6
8	Түлш шатах тослох материал	27	24.9	-2.1	0.1
9	Барилгын засварын материал	71.4	72.4	1	0.3
10	Хүнсний материал	208.1	197.1	-11	0.8
11	Бусад хангамжийн материал	1462.4	21081.8	19619.4	85.8
12	Мал амьтад	226	330.9	104.9	1.3
	Нийт	4358.4	24568.2	20209.8	100

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл, аж ахуйн материал 333.0 сая төгрөг, бусад хангамжийн материал 19,619.4 сая төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 38.2 сая төгрөг, эм боох материал 20.2 сая төгрөг, тусгай зориулалтын материал 127.7 сая төгрөг, мал амьтад 104.9 сая төгрөгөөр тус тус өссөн бол дуусаагүй үйлдвэрлэл 5.8

сая төгрөг, бичиг хэргийн материал 8.5 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 7.2 сая төгрөг, түлш шатах тослох материал 2.1 сая төгрөг, хүнсний материал 11.0 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийт бараа материалын данс 26,800.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 17,811.8 сая төгрөгийн, хандив тусламжаар 166.9 сая төгрөгийн, шилжүүлж авсан 8,039.8 сая төгрөгийн бараа материал эзэлж байгаа бол бусад хэлбэрээр 804.8 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд нийт бараа материалын дүн 6,027.85 сая төгрөгөөр буурснаас 6,225.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу худалдсан, 251.5 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн /зарим нь бүтцийн өөрчлөлттэй холбоотой/, бусад байдлаар 113.6 сая төгрөгөөр бараа материалын данс буурсан байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2015 оны эцэст 315,198.6 сая төгрөг байсан бол тайлант онд 17.6 хувь буюу 34,425.1 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны эцэст 349,623.7 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хөрөнгө тус бүрээр харуулбал:


		/Сая төгрөгөөр/		
№	Хөрөнгийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт Бууралт +/ -
1	Барилга байгууламж, орон сууц	150292	193639.3	43347.3
2	Тээврийн хэрэгсэл	8083.8	8561.4	477.6
3	Машин тоног төхөөрөмж	14338.5	21269.5	6931
4	Тавилга эд хогшил	6430.2	7849.8	1419.6
5	Зам гүүрийн байгууламж	34161.4	34828.9	667.5
6	Түүх соёлын дурсгалт зүйл	1234.1	1246	11.9
7	Дуусаагүй барилга байгууламж	87212	60782.8	-26429.2
8	Номын фонд	580.7	630.9	50.2
9	Бусад үндсэн хөрөнгө	12329.6	20291.5	7961.9
10	Программ хангамж	515.1	498.8	-16.3
11	Бусад биет хөрөнгө	21.2	24.8	3.6
	Нийт	315198.6	349623.7	34425.1

Нийт үндсэн хөрөнгийн 55,3 хувийг барилга байгууламж, 17,3 хувийг дуусаагүй барилга, 4,5 хувийг машин тоног төхөөрөмж, 17,3 хувийг бусад үндсэн хөрөнгө, 2,4 хувийг тээврийн хэрэгсэл, 2,2 хувийг тавилга, эд хогшил болон бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 69,275.9 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 1,218.5 сая төгрөг, хандив тусламжаар 11,854.7 сая төгрөг, шилжүүлж авсан 12,549.1 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр 59.7 сая төгрөг, бусад 43,593.8 сая төгрөг/ нэмэгдэж, 34,850.9 сая төгрөгөөр /үүний дотор худалдсан 46.2 сая төгрөг,

акталсан 1,190.3 сая төгрөг, шилжүүлсэн 32,131.8, бүтцийн өөрчлөлтөөр 114.5 сая төгрөг, бусад 1,368.0 сая төгрөг/ хасагдаж, тайлант онд 11,088.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг графикаар харуулбал:



Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч бүртгэн санхүүгийн тайландаа тусгана Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана” заасны дагуу ТЕЗ нь санхүүгийн нэгтгэл тайланд хэрэгжүүлж ажилласан байна.

Өр төлбөр бүртгэл, тайлагналын талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 88,451.1 сая төгрөг тайланд онд 4,167.8 сая төгрөгөөр буурч, оны эцэст 84,283.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийг дэлгэрэнгүй харуулбал:

		/Сая төгрөгөөр/		
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /-/ Бууралт +/-
1	Ажилчидтай холбогдсон өглөг	216.2	88.6	-127.6
2	Бараа үйлчилгээний зардлын өглөг	283	37.1	-245.9
3	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1900.2	8608.6	6708.4
4	Байгууллагад төлөх өглөг	3652.1	13889.7	10237.6
5	Хувь хүмүүст төлөх өглөг	75	24	-51
6	Татварын өглөг	21.7	42.9	21.2
7	НДШ-ийн өглөг	15.9	22	6.1
8	Дансны өглөг	432.5	43	-389.5

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

9	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	66797.4	45963.6	-20833.8
10	Бусад урьдчилж орсон орлого	715.2	15.9	-699.3
11	Бусад урт хугацаат өр төлбөр	14341.9	15547.9	1206
	Нийт	88451.1	84283.3	-4167.8

Нийт өр төлбөрийн 54,5 хувийг засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв эзэлж байгаа бөгөөд төсөвт байгууллагуудын байгууллагад төлөх өглөг 10,237.6 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 6,708.4 сая төгрөг, Татвар, НДШ-ын өглөг 27.3 сая төгрөг, Бусад урт хугацаат өр төлбөр 1,206.0 сая төгрөгөөр өглөгийн дүн тус тус нэмэгдсэн байна.

Орлогын бүртгэл, тайлагналын талаар:

1. Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын талаар:

ТЕЗахирагчийн 2016 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого 197,884.1 сая төгрөгөөр тайлагнагдсан ба өмнөх онтой харьцуулахад 17,188.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант оны орлогын бүтцийг авч үзвэл татварын орлого 61,512.6 сая төгрөг, татварын бус орлого 15,259.7 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 121,111.8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

2. Төсвийн орлого, санхүүжилтийн талаар:

Өмнөговь аймгийн ТЕЗ нь 2016 онд ОНХСангийн орлогын шилжүүлэг 21,515.0 сая төгрөг баталагдснаас гүйцэтгэлээр 21,515.0 сая төгрөг санхүүжилтийг бүрэн авч, Тусгай зориулалтын шилжүүлэг төлөвлөгөөгөөр 27,439.0 сая төгрөг авахаас гүйцэтгэлээр 27,405.7 сая төгрөгийг авч 33.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Аймгийн 2016 оны төсвийн орлого эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаас 153,662.4 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлого 112,401.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 98,715.0 сая төгрөгийн төсвийн орлогыг бүрдүүлж, 8,317.7 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг 107.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

/сая.төгрөг/

2016 он

Үзүүлэлт	Анх батлагдсан дүн	Тодотгол-1	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	108,793.9	112,401.5	120,719.2	
УРСГАЛ ОРЛОГО	67,795.3	63,193.4	64,764.4	
Татварын орлого	59,459.9	57,052.1	61,241.0	
Татварын бус орлого	8,335.4	6,141.1	3,523.4	
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	255.4	167.7	58.5	
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	40,743.2	49,040.5	55,896.3	

3. Татварын болон татварын бус орлогын талаар:

Өмнөговь аймгийн төсөвт төвлөрөх 2016 оны урсгал орлогыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9-р хуралдааны 7 дугаар тогтоолоор 58,251.1 сая төгрөгөөр баталсан байна.

Татварын орлогын 2016 оны төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын хуралдаанаар 1 удаа тодотгол хийгдсэн байна.

✚ Өмнөговь аймгийн ИТХурлын 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 2-р хуралдааны 1 дүгээр тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 732.1 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 138.0 сая төгрөг, АТБӨЯХАТатварын орлогыг 93.0 сая төгрөг, Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,523.6 сая төгрөг, нэр зааж ангилаагүй орлогыг 327.0 сая төгрөг, татварын буцаан олголтыг 13.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 230.0 сая төгрөг, газрын төлбөрийг 305.5 сая төгрөг, усны төлбөрийн орлогыг 2,050.0 сая төгрөг, хувьцааны ногдол ашиг 260.0 сая төгрөг, хүү торгуулийн орлого 115.0 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлогыг 50.0 сая төгрөгөөр бууруулснаар 58,040.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 2,321.5 сая төгрөгөөр тодотгон баталснаар 2016 оны аймгийн урсгал төсвийн орлого нийт 60,361.5 сая төгрөгөөр батлагдсан байна.

2016 оны аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 64,928.0 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 1,011.3 сая төгрөгийг хасч тооцоход 63,916.7 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 4,566.1 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

2016 оны татварын ба татварын бус орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал:

						/сая төгрөг/	
Орлогын төрөл				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /дүнгээр/	Биелэлт /хувиар/
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого				24,639.0	24,925.6	286.6	1.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт				(1,011.3)	(1,011.3)	-	-
Үйл ажиллагааны орлого				623.6	744.7	121.1	19.4
Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэдийн орлого				19.8	20.3	0.5	2.5
Хөрөнгийн орлого				61.4	48.1	(13.3)	(21.7)
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар				12,988.0	13,339.7	351.7	2.7
Бууны албан татвар				29.8	29.4	(0.4)	(1.3)
АТБӨЯХАТатвар				1,849.0	2,684.5	835.5	45.2
Улсын тэмдэгтийн хураамж				253.1	245.9	(7.2)	(2.8)
Хог хаягдлын хураамж				270.0	468.4	198.4	73.5
Үйлдвэр үйлчилгээний усны төлбөр				13,550.0	15,921.7	2,371.7	17.5
Газрын төлбөр				3,230.2	3,357.9	127.7	4.0
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр				0.2	0.2	-	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр				12.5	126.9	114.4	915.2

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	595.1	468.4	(126.7)	(21.3)
Хувьцааны ногдол ашиг	200.0	200.0	-	-
Хүү, торгуулийн орлого	467.1	866.9	399.8	85.6
Түрээсийн орлого	8.9	53.0	44.1	495.5
Төсөвт газрын өөрийн орлого	1,595.1	1,182.4	(412.7)	(25.9)
Бусад нэр заагдаагүй орлого	870.7	1,196.9	326.2	37.5
Хөрөнгө худалдсаны орлого	109.7	58.4	(51.3)	(46.8)
УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	60,361.9	64,928.0	4,566.1	7.6

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Биелэлт	Хувиар
1	Сумдын ЗДТГ	127.1	113.9	(13.2)	(10.4)
2	ТЗШ-ийн байгууллагууд	477.3	77.9	(399.4)	(83.7)
3	Аймгийн төвийн ТЗШ	990.7	990.7	-	-
	Дүн	1595.3	1182.5	(412.8)	(25.9)

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 107.6 хувиар биелүүлсэн боловч нэр төрлөөр авч үзвэл цалин хөлс түүнтэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлого, орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэдийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, АТБӨАХАТатвар, хог хаягдлын хураамжийн орлого, үйлдвэрлэл үйлчилгээний усны төлбөрийн орлого, газрын төлбөр, рашаан усны нөөц ашигласны төлбөр, хүү торгуулийн орлого, түрээсийн орлогыг 1.2-915.2 хувиар давуулан биелүүлж, хөрөнгийн орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, ТТАМАТөлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлого, хөрөнгө худалдсны орлого зэрэг нь 1.3-46.8 хувиар тасарсан байна.

Сумдын орлогын төлөвлөгөө 2,321.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,775.0 сая төгрөг буюу 19,5 хувиар давуулан биелүүлсэн байна. Сумдаар дэлгэрэнгүй авч үзвэл 13 сум 100,8-157,8 хувиар биелүүлж, Баяндалай, Номгон сум 6,4-13,3 хувиар тасалсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого төлөвлөгөөгөөр 58,040.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 62,047.8 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 4,007.4 сая төгрөг буюу 106.9 хувиар биелүүлсэн байна. Аймагт төвлөрөх орлогыг 12 сум 101,2-195,6 хувиар биелүүлж, Хүрмэн, Цогт-Овоо, Цогтцэций сум 0,4-14,6 хувиар тасалсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 12,068.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 16,157.2 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 4,088.5 сая төгрөг буюу 133,8 хувиар биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 13 сум 101,9-614,3 хувиар биелүүлж, Баяндалай, Булган сум, татварын хэлтэс 0,4-23,8 хувиар тасалсан байна.

4. Тусламж, санхүүжилтийн орлогын талаар:

Тусламж, санхүүжилтийн орлогод ОНХСангийн шилжүүлэг 21,515.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 27,405.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 3,204.1 сая төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 67,215.4 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 154.5 нийт 119,494.7 сая төгрөгийн орлого бүртгэгдсэн байна.

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Тусламж, санхүүжилтийн орлого өмнөх оноос 27,004.9 сая төгрөгөөр өссөн ба тайлант оны нийт тусламж, санхүүжилтийн орлогын 67,215.4 сая төгрөг буюу 56,2 хувь нь орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого эзэлж байна.

Зардлын бүртгэл, тайлагналын талаар:

2016 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн зарлагыг 118,183.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 107,745.5 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж 10,438.1 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

ТЕЗ-ийн 2016 оны нийт зарцуулалтыг төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар төлөвлөгөө гүйцэтгэлийг гаргаж хүснэгт №1-д харуулав.

/төгрөгөөр/

Төсвийн зарлагын нэр төрөл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэтрэлт, хэмнэлт
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,183,657,800	107,745,555,185	10,438,102,615
УРСГАЛ ЗАРДАЛ	63,417,360,100	60,710,358,722	2,707,001,378
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,757,475,800	37,343,869,950	2,413,605,850
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,090,542,300	20,875,902,544	214,639,756
Үндсэн цалин	17,978,292,400	18,060,753,575	(82,461,175)
Нэмэгдэл	1,760,928,900	1,558,329,896	202,599,004
Унаа хоолны хөнгөлөлт	155,634,400	145,071,736	10,562,664
Урамшуулал	855,214,000	771,380,687	83,833,313
Гэрээт ажлын хөлс	340,472,600	340,366,649	105,951
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,381,678,400	2,342,475,097	39,203,303
Тэтгэврийн даатгал	1,553,425,900	1,648,441,765	(95,015,865)
Тэтгэмжийн даатгал	156,089,900	113,094,866	42,995,034
ҮОМШӨ-ний даатгал	206,759,900	153,085,649	53,674,251
Ажилгүйдлийн даатгал	54,668,300	132,634,281	(77,965,981)
Эрүүл мэндийн даатгал	410,734,400	295,218,535	115,515,865
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,394,046,200	4,238,948,681	155,097,519
Гэрэл, цахилгаан	551,721,300	535,500,007	16,221,293
Түлш, халаалт	3,442,555,500	3,353,291,220	89,264,280
Цэвэр, бохир ус	387,535,800	339,907,786	47,628,014
Байрны түрээс	12,233,600	10,249,668	1,983,932
Хангамж, бараа материалын зардал	1,681,918,000	1,649,143,599	32,774,401
Бичиг хэрэг	153,169,600	153,827,950	(658,350)
Тээвэр, шатахуун	661,462,500	649,943,917	11,518,583
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	214,968,600	201,720,071	13,248,529
Ном, хэвлэл	76,490,000	74,899,430	1,590,570
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	325,760,700	318,135,784	7,624,916
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,066,600	250,616,447	(549,847)
Нормативт зардал	2,263,278,400	2,256,364,183	6,914,217
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	158,076,200	160,541,429	(2,465,229)
Хоол, хүнс	1,949,097,700	1,941,912,951	7,184,750
Нормын хувцас, зөөлөн эдлэл	156,104,500	153,909,803	2,194,697
Эд хогшил, урсгал засварын зардал	977,653,000	914,998,488	62,654,512
Багаж, техник, хэрэгсэл	265,419,600	259,498,003	5,921,597
Тавилга	311,876,000	278,355,836	33,520,164
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-
Урсгал засвар	400,357,400	377,144,649	23,212,751
Томилолт, зочны зардал	201,618,600	175,906,330	25,712,270
Гадаад албан томилолт	5,000,000	4,817,200	182,800
Дотоод албан томилолт	196,618,600	171,089,130	25,529,470
Зочин төлөөлөгч хүлээн авах			-

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,383,036,300	2,279,126,930	103,909,370
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,363,251,400	2,259,483,524	103,767,876
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,961,400	5,007,075	954,325
Даатгалын үйлчилгээ	2,301,200	1,941,150	360,050
Тээврийн хэрэгслийн татвар	2,263,800	1,935,906	327,894
Тээврийн хэрэгслийн оношлогоо	701,700	422,727	278,973
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,154,600	7,750,950	(2,596,350)
Газрын төлбөр	1,363,700	1,187,598	176,102
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,038,500	1,398,000	640,500
Бараа үйлчилгээний бусад зардал	4,383,704,600	2,611,004,097	1,772,700,503
Бараа үйлчилгээний бусад зардал	4,055,194,900	2,285,110,768	1,770,084,132
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	328,509,700	325,893,329	2,616,371
ТАТААС	183,089,800	180,075,000	3,014,800
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	183,089,800	180,075,000	3,014,800
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	183,089,800	180,075,000	3,014,800
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,476,794,500	23,186,413,772	290,380,728
Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,789,930,100	16,789,430,100	500,000
Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,789,930,100	16,789,430,100	500,000
Бусад урсгал шилжүүлэг	6,686,864,400	6,396,983,672	289,880,728
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,958,290,600	4,723,532,368	234,758,232
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,207,900	9,204,978	2,922
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	560,732,000	531,789,210	28,942,790
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	597,408,200	593,405,194	4,003,006
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	383,807,600	380,568,782	3,238,818
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	177,418,100	158,483,140	18,934,960
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,766,297,700	47,035,196,464	7,731,101,237
Дотоод эх үүсвэрээр	54,766,297,700	47,035,196,464	7,731,101,237
Их засвар	15,776,500,000	15,727,294,181	49,205,819
Бусад хөрөнгө	38,989,797,700	31,307,902,282	7,681,895,418


ТЕЗ-ийн тайлант оны төсвийн зарлага өмнөх оноос 26,237.3 сая төгрөгөөр өссөн байна. Зардлын бүтцээр харуулав.

	/сая төгрөгөөр/		
Төсвийн зарлагын нэр төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оноос өссөн дүн
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,508.2	107,745.5	26,237.3
УРСГАЛ ЗАРДАЛ	38,435.9	60,710.3	22,274.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,134.0	37,343.8	5,209.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,837.2	20,875.9	1,038.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,143.8	2,342.4	198.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,526.6	4,238.9	712.3
Хангамж, бараа материалын зардал	1,356.8	1,649.2	292.4
Нормативт зардал	2,075.5	2,256.4	180.9
Эд хогшил, урсгал засварын зардал	522.0	915.0	393.0

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Томилолт, зочны зардал	175.3	175.9	0.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	639.2	2,279.1	1,639.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,861.4	2,611.0	749.6
TATAAC	137.8	180.0	42.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,164.0	23,186.5	17,022.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,072.3	47,035.2	3,962.9

ТЕЗ-ийн төсвийн зарлагад эзлэх хувийг зардлын бүлгээр графикаар харуулав.



Графикаас харахад хөрөнгийн зардал 47,035.2 сая төгрөг буюу 43,6 хувь, цалингийн зардал 20,875.9 сая төгрөг буюу 19,4 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 16,648.0 сая төгрөг буюу 15,5 хувь, урсгал шилжүүлэг 23,186.4 сая төгрөг буюу 21,5 хувийг тус тус эзэлж байна.

Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр батлагдсан Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын в.3 /тавилга шинээр худалдан авахгүй байх/, в.6 /төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх/ дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй Төсвийн Ерөнхийлөн Захирагч орон нутгийн хөрөнгө оруулалтаас 178.9 сая төгрөгийн автомашин, төсвийн хөрөнгөөр 278.3 сая төгрөгийн тавилга эд хогшил шинээр худалдан авсан байна.

ОН-ийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагналын талаар:

ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын ОНӨААТҮГ-ууд болох эрчим, эмийн эргэлтийн сан, нийтлэг үйлчилгээний газар, Дулаан хангамж, АЗДТГ-ын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар, Хөгжил хөрөнгө оруулалтын газар, Буянт хотхон хүүхдийн зуслан зэрэг 36 байна.

Тайлант онд орон нутгийн өмчит Сэврэй, Баян-овоо, Цогт-овоо, Номгон, Ханбогд, сумдын ААТҮГ-ууд ашигтай ажиллаж, Баяндалай сумын Гурванмөнх,

Манлай сумын Манлайн бадрах, Цогтцэций сумын Цог-өрнөх, Ханхонгор сумын Элка, Хүрмэн сумын Эрдэнэсийн буян ААТҮГ-ууд батлагдсан төсвийн зарлагын хэтрүүлэн зарцуулж Хязгаарлалттай санал дүгнэлт авлаа.

Төсөл, сангуудын талаар:

ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 төсөл сангууд нэгтгэгдсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сан 16
- Сум хөгжүүлэх сан 15
- Байгаль хамгаалах сан 1
- Тендерийн хороо, хөрөнгө оруулалтын барьцаа 1
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан 1
- Засаг даргын нөөц сан 1
- Өмнөговь хөгжлийн сан 1
- Халамжийн сан тус тус ОНТС нэгтгэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5102.9 сая төгрөгийн хөрөнгийг НББ тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6²-д заасан дагуу холбогдох байгууллагууд бүртгэлд тусгасан байна.

Аудитаар Ханхонгор сум 18.1 сая төгрөгийн өртөгтэй боловсролын салбарын тоног төхөөрөмж, Хүрмэн сум 73.4 сая төгрөгийн өртөгтэй 0.4 кв-ын агаарын шугам, гудамжны гэрэлтүүлгийн өргөтгөлийн ажлуудыг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн.

2.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 119, төсвийн төвлөрүүлэн захирагч 15, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 32 байгууллага нийт 166 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас зөрчилгүй санал дүгнэлт 114, хязгаарлалттай санал дүгнэлт 5, түүвэрт хамрагдсан 32, итгэл үзүүлэн өнжөөсөн 15 байгууллага байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж 13,935.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,486.1 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 83,8 сая төгрөгийн алдаа зөрчилд, өр авлага, нягтлан бодох бүртгэл, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж, 2.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 175,7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 6 албан

¹ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

² ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.

тушаалтанд хариуцлага тооцуулах 187.2 сая төгрөгийн албан шаардлага тус тус өгч ажиллалаа.

Тухайлбал

- Ажиллагсадтай холбоотой зардал дансанд актын төлбөрийн дүнгээр нэмэгдүүлэн тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд худалдаж авсан хөрөнгийг үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн
- Хувь хүний орлогын албан татварыг тооцохдоо сард эдлэх 7000 төгрөгийн хөнгөлөлтийг давхардуулан илүү, дутуу олгосон
- Нийгмийн даатгалын байгууллагаас санхүүжсэн, нэр данс зөрүүтэй буцаж орсон гүйлгээг журналд тусгаж төсөвт зардлуудын дүнг өсгөж тайлагнасан
- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өр төлөхдөө тооцоо нийлсэн акт, өмнөх хугацаанд өр үүсгэж бүртгэсэн нэхэмжлэх, холбогдох баримтыг бүрдүүлэн хавсаргаагүй, шууд зардалд бичсэн
- Бараа материалын орлогын төрлийг буруу сонгосноос бараа материалын тодрууллагын тайланд үнэгүй авсан бараа материалын дүн дутуу тайлагнасан
- Цалингийн тооцоог цалингийн цэс, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлан, мөнгөн гүйлгээний журнал, авлага, өглөгийн журналуудтай тулгаж үзэхэд ХХОАТ-ын өглөг, ҮЭ татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй
- Худалдаж авсан үндсэн хөрөнгө бүртгээгүй, биеийн тамирын хэрэгслийг бөөн дүнгээр бүртгэсэн
- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг өмнөх үеийн үр дүнгээр нэмэгдүүлэн тайлагнасан
- ЗДНөөц сангаас шинэ жилийн арга хэмжээ, бэлэг, гар утасны нэгжийн төлбөр зэрэг зориулалт бус зардлыг санхүүжүүлсэн зөрчлүүд байна

Эдгээр зөрчилүүд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 / санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, бүртгэж тайлагнах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.3.2 / санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, бүртгэж тайлагнах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, УСНББОУС, НББ-ийн тухай хууль, холбогдох хууль журам, зааврыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилаа.

(Сая төгрөгөөр)

№	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа			Нийт зөрчил		
		Дүн	Заглуулсан	Заглуулагдаагүй	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	Хөрөнгө оруулалт: төсвийг зориулалт бус зарцуулсан	1,338.0		1,338.0			1,338.0
2	Авлага данс: ААН тэй хийсэн орон сууцны гэрээний хугацаа дууссан	10,958.9		10,958.9			10,958.9
3	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар автомашин тавилга эд хогшил авсан	457.2		457.2			457.2
4	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө бүртгэлд тусгаагүй	176.6		176.6			176.6
5	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан бусдаар дуусаагүй барилга байгууламж шилжүүлсэн хөрөнгийг дансны хасалт хийснээр эцсийн хөрөнгийг буруу илэрхийлэгдсэн	5,021.8	5,021.8				
дүн		17,952.5	5,021.8	12,930.7	-	-	12,930.7

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг анхаарч зөрчлийг дахин давтаж гарсан эсэхийг авч үзэх.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өмнөговь аймгийн Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардал 63,414.2 хөрөнгийн зардалд 54,766.3 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	118,183.6	107,745.6	91,1%	10,438.0
1.1	Урсгал зардал	63,417.3	60,710.5	95.7%	2,706.8
1.2	Хөрөнгийн зардал	54,766.3	47,035.2	85,8%	7,731.1
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	118,183.6	112,752.6	95,4%	5,427.8
2.1	Улсын төсвөөс санхүүжих	51,861.8	49,588.4	95,6%	2,270.3
2.2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,871.5	61,920.4	95,4%	2,951.1
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1,450.3	1,243.8	85,7%	206.4

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 107,745.5 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 60,710.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 47,035.2 төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд шинэчлэгдсэн цахим хуудсанд шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1³-д заасны дагуу улсын төсвийн 40 байгууллага, түүний харъяа 3 сан, орон нутгийн төсвийн 141 байгууллага, ОНӨААТ 36 үйлдвэрийн газар нийт 217 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Монгол Улсын Ерөнхий Аудиторт ЯАГ-аас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг 2 удаа хийж аудитаар нийт 13,820.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 7,646.2 сая төгрөгийг аудитын явцад залруулж, 6,174.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

³ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

Өмнөговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийг 88,9 хувь хэрэгжүүлэн тухай бүр, сар бүр, улирлаар, хагас бүтэн жилээр оруулах мэдээллүүдийг бүрэн оруулж хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан аж ахуй нэгж нийт төсөвт өртөг, ажлын хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг журмын дагуу мэдээлэх үүргийг төсвийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбараар хэрэгжүүлэн ажиллаж байна.

